



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/173

Булган сум

Чанарын шаардлага хангахгүй
болсон өвс, тэжээлийг устгалд оруулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аюулгүйн нөөцөд 2021 онд бэлтгэсэн тэжээлээс чанарын шаардлага хангахгүй болсон тухай мэргэжлийн хяналтын байцаагчийн 2022 оны 06-02-010/92 дугаар дүгнэлтийн дагуу хавсралтад заагдсан тэжээл, аймгийн Нөөцийн газарт хадгалагдаж байгаа хадгалалтын горим алдагдсан хавсралтад заагдсан өвсийг устгах ажлыг зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (Ш.Баасандорж), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК (Ш.Өлзийхутаг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 21-ны өдрийн А/13 дугаар
захирамжийн хавсралт



УСТГАЛД ОРУУЛАХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

Д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ	Байршил
1	2	3	4
1	Өвс	2077 боодол	Аймгийн Нөөцийн газар
		4489 боодол	Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн хашаа
		1000 боодол	Сэлэнгэ сумын 5 дугаар багийн иргэн Х.Эрхэмбаярын хашаа
Нийт		7566 боодол	
2	Тэжээл	32.3 тонн	Аймгийн Нөөцийн газар
		11.6 тонн	Хишиг-Өндөр сумын Мааньт баг Дэлхийн Зөн ОУБ-ын харьяалалд байсан хуучин байр
Нийт		43.9 тонн	